

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
**2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

“Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/284 захирамжийн дагуу 07 дугаар сарын 6,7 нд Хатгал тосгоны Жанхайн Цагаан эрэгт “Цаатан фестивал”, 7 дугаар сарын 20, 21, нд Алаг-Эрдэнэ суманд “Сарлаг наадам”, 7 дугаар сарын 21,22 нд Цагаан-Үүр суманд “Монгол бөхийн баяр”, 7 дугаар сарын 28, 29 нд Чандмань-Өндөр суманд “Алунгоо эхийн сургаалын баяр” эвэнт арга хэмжээнүүд тус тус зохион байгуулагдсан.

Аймгийн Засаг дарга П.Лхагважав агентлаг байгууллагын удирдагуудын сарын цугларалтыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр танхимаар, сумдын удирдлагуудтай 2023.06.30-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж, ажлын үүрэг чиглэл өглөө.

2023 оны Төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу 3 хөмрөгийн 656 хадгаламжийн нэгжийн 26538 хуудас бүхий цаасан суурьтай баримтаар нөхөн бүрдүүлэлт хийсэн. Мөн 06 дугаар сард 6 хөмрөгийн 151 хадгаламжийн нэгжийн 8591 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу 153 иргэн, 9 байгууллагад архивын баримтын лавлагаа мэдээллийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

**Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:**

**ХҮНСНИЙ ЧАНАР СТАНДАРТ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТААР:**

Ардын хувьсгалын 102 жил, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023.02.14-ний өдрийн 08-00/01 дугаартай “Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар хүнс, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газруудад Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох дүрэм журам, стандарт, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, хоол хүнсээр дамжих хордлого, халдвар, болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2023.06.20 - 2023.06.30 хүртэлх хугацаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Энэ хүрээнд баяр наадмыг зохион байгуулахтай холбогдуулан нийт 24 сумын Засаг даргын тамгын газарт хоол хүнсний аюулгүй байдлыг хангуулах талаар улсын ахлах байцаагчийн 2 төрлийн зөвлөмжийг гарган хүргүүлсэн.

Хоол, хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн технологи ажиллагааны горим, ашиглаж буй түүхий эд, боловсруулсан болон худалдан борлуулж буй хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, гарал үүсэл, баталгаажилтын баримт бичиг, хаяг шошгын мэдээлэлд

хяналт тавьж, ундны усны эрүүл ахуйн чанар, ус хадгалах савны зориулалт, угаалга цэвэрлэгээ, хуванцар болон нэг удаагийн аяга таваг, нийлэг уутны баталгаажилт, ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдал, дотоод хяналтыг хэрхэн зохион байгуулдаг зэрэг асуудлыг шалгалаа.

Баяр наадам зохион байгуулах хорооны даргын баталсан хуваарийн дагуу баяр наадмын өдрүүдэд наадмын талбай, морь барианы газар, Чингүнжавын талбайд хяналт шалгалт хийж, хуушуурын гэр, худалдааны газруудын ажлын байр, орчны эрүүл ахуй, бохир ус, хог хаягдал зайлуулах нөхцөл шаардлагыг хангасан эсэх, хоол үйлдвэрлэлд хэрэглэж буй мах, сүүний гарал үүсэл, шинжилгээ, хадгалалт, худалдаалж буй хүнсний бараа бүтээгдэхүүний чанар, хугацаа, шошгын мэдээлэл шаардлага хангасан эсэх, хүнстэй харьцагч хөдөлмөр хамгааллын хувцас, гар угаах нөхцлөөр хангагдсан байдал, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан эсэхэд хяналт хийлээ. Шалгалтанд Мөрөн сумын Далай ээж, Цагаан-Уул, Шинэ Мөрөн хүнсний зах болон хүнс үйлдвэрлэлийн 3, худалдаа эрхлэгч 165, хоолны газар 16, баяр наадмын үеэр үйл ажиллагаа явуулж байсан 64 хуушуурын гэр, шорлогны цэг 3, нийт 252 объект хамрагдлаа.

### **БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбарын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 01/20 дугаартай удирдамжийн хүрээнд Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар, Хөвсгөл нуур эгийн голын захиргаатай хамтран хяналт шалгалтын ажлыг 2023.06.12-2023.06.18-ны өдрүүдэд Хөвсгөл нуурын зүүн, баруун эрэг дагуух 67 жуулчны баазад шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтээр тавигдсан шаардлага биелүүлээгүй, ус ашиглах гэрээ, дүгнэлтгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй зэрэг зөрчлүүдийг илрүүлж зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасны дагуу 9 иргэн, аж ахуйн нэгжид 6 сая төгрөгийн торгууль тавьж, торгуулийн барагдуулалт 90 хувьтай байна.

Мөн Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны улсын байцаагчтай хамтран 2023 оны 01-33-01/079/27 дугаартай хугацаатай 5 заалт бүхий хугацаатай албан шаардлагыг өгч ажиллалаа. Мөрөн сумын иргэн Б.Түмэннасанд холбогдох зөрчилд зөрчлийн №2338000423 дугаартай, иргэн Б.Батдоржид холбогдох №2338000424 дугаартай, иргэн Т.Тамирт холбогдох №2338000425 дугаартай, Түнэл сумын Ганданнуурын хөвөө ХХК-д холбогдох №2338000426 дугаартай, мөн сумын Их Түнэл ХХК-д холбогдох №2338000427 дугаартай зөрчлийн хэрэг нээж, шалгах ажиллагааг хийж, Прокурорын хяналтанд шилжүүлж ажиллалаа. Мөрөн сумын төвлөрсөн модны цэгийн хашааг бариулах ажлыг хийлгүүлж байна. Жаргалант, Галт сумдын байцаагч нарт ойн хортон устгалын ажилд хяналт тавьж ажиллах талаар зөвлөгөө заавар өглөө.

2023 оны 6 дугаар сард Тосонцэнгэл сумын Тосон илч ХХК, Тариалан сумын Тариалан НАҮТ ХХК-ийн дулааны төвийн зуухнуудад хяналт шалгалт хийж, байгаль орчны ерөнхий үнэлгээг хийлгэх, 2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хийж, батлуулах, газрын төлөв байдал чанарын хянан магадлагааг хийлгэх, ус ашиглах дүгнэлт, хаягдал усны дүгнэлтийг гаргуулах, зуухны түлшний дүгнэлтийг гаргуулах ажлыг хийлгэх албан

шаардлагыг хүргүүлээ. Их эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 1 ААНэгж үнэлэгдэж, эрсдлийн дундаж 49 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 50 хувьтай шалгагдсан.

### **ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА:**

Монгол Улсын Шадар сайдын баталсан Шар усны үер, Ой хээрийн түймэр, Үер усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн удирдамжит ажлын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Нэгдсэн удирдамжит ажлын хүрээнд “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын А/139 дүгээр захирамжийг 23 сум,1 тосгонд хүргүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Сүм хийдийн барилга байгууламжид Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын дүрэм, Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах Гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд тус аймгийн Мөрөн, Тариалан, Хатгал тосгон, Цагаан-Уул, Галт зэрэг сумдын нутаг дэвсгэрт байрлах Сүм, хийд болон Сумдад үйл ажиллагаа явуулдаг нийт 14 иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

Сүм, хийдийн барилга байгууламжид гүйцэтгэлийн хяналт шалгалтаар нийт 14 байгууллага хамрагдсан. Хяналт шалгалтаар нийт 42 зөрчил илэрч, 25 зөрчлийг үзлэг шалгалтын явцад засуулж, 14 зөрчил дутагдлыг арилгуулахаар удирдах албан тушаалтанд хугацаатай үүрэг өгч хяналт тавин ажиллаж байна.

Стратегийн Команд штабын дадлага сургуулийн хүрээнд мөн улс орон даяар газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтэд цэгцтэй мэдлэл мэдээлэл олгох “Бэлэн бай” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд дараах ажлууд хийгдсэн.

Онцгой байдлын газраас хийж хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээг сурталчилсан мэдээ мэдээлэл 34-г байршуулснаар 2542 удаа шейр хийж, 45852 хүн хандсан байна.

Аяны хүрээнд Гал түймэр унтраах, аврах 46,69,73,76 дугаар ангиуд “БИД БЭЛЭН, ТА БЭЛЭН ҮҮ” чөлөнөхийг эхлүүлэн хариуцсан сумдын иргэд, хөдөлмөрчид, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагч нарт, сургууль, цэцэрлэгүүдэд Бэлэн бай аяны зурагт хуудсан дээр байрлаж байгаа QR кодыг уншуулах заавар, зөвлөмж, Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулж ажилласан.

23 сум, 1 тосгоны Сургагч багш нарт Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа О.Ганбат, ангиллын сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Г.Болортуяа нар цахим уулзалт зохион байгуулан “Стратегийн команд штаб”, Бэлэн бай аяны хүрээнд хийгдэх ажлын чиглэл өгч ажилласан.

2023 оны 06 дугаар сард Хөвсгөл аймгийн 6 суманд объектын гал түймрийн 9 дуудлага мэдээдлэл ирж, гал түймрийн улмаас өвөл зуны сууц-3, гэр-5, автомашин-1, гал түймэрт өртөж 103,817, /Зуун гурван сая найман зуун арван долоон мянган төгрөг/-ний хохирол учирсан байна. Дээрх гал түймрийн хэрэг зөрчлүүд дээр холбогдох хуулийн дагуу эрх зүйн бичиг баримтыг бүрдүүлж 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, хэргийг прокурорт хянуулан ажиллав.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Их-Уул багийн “Найман толгой” гэдэг газар Дэлгэрмөрөн голд /аймгийн төвөөс баруун урд зүгт 30 км-т, сумын төвөөс зүүн хойд зүгт 18 км-т/ иргэн А.Даваасүрэн /7 настай, эрэгтэй, Бүрэнтогтох сумын харъяат/ өндөр эргээс унаж осолдсон тухай дуудлагыг 2023.06.09-ний өдрийн 15:38 цагт хүлээн авсан. Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч хошууч Л.Ганзоригоор ахлуулсан нийт 7 алба хаагч, 1 автомашинтай, 1 завьтай, ар гэрийн 13 хүн, 3 автомашинтай. Нийт 20 хүн, 4 автомашин, 1 завьтайгаар 2023.06.12-ны өдрийн 07:00 цагт эрлийн ажиллагааг 2 бүлэгт хуваан эхэлсэн. 1-р бүлэг завиар Осол болсон газраас доош 50км-т урсаж, мөн 2 усчин аврагч 1-2 метрийн гүнд тус бүр 10 удаагийн шумбалтыг 100 метрийн зайд хийж “Хилэнтийн гүүр” гэдэг газар хүртэл эрэл хийсэн. 2-р бүлэг Осол болсон газраас “Хилэнтийн гүүр” хүртэл 30км-ийн зайд голын салаа бүрийг самнаж эрэл хийсэн.

Голын урсгал ширүүн, үер ихтэй, эргүүлэгтэй, үзэгдэх орчин хязгаарлагдмал, усны түвшин их тул бүлгүүд эрлийн ажиллагааг түр зогсоож үерийн төвшин багасаж, үзэгдэх орчин бүрдтэл эрлийг түр зогсоох талаар ар гэрийнхэнтэй нь зөвшилцсөний үндсэн дээр Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ё.Пүрэвсүрэнгийн зөвшөөрлөөр эрлийг түр зогсоож ангийн байрлуу буцсан. Эрлийн үйл ажиллагааг 2023 оны 06 сарын 22-ны өдөр дахин эхлүүлж Бүрэнтогтох сумын Тултын тохой гэх газраас цогцосыг олж ар гэр болон цагдаа, эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгсөн.

#### **Гэмт хэрэг, зөрчлийн чиглэлээр:**

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр, Цагдаагийн ерөнхий газар, Цагдаагийн газрын зорилт, бодлого чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажлаа уялдуулан хамтран ажиллалаа.

Гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр 90 мэдэгдэл бичиж 54 мэдэгдлийн хариуг хугацаанд нь авч, мэдэгдлийн мөрөөр 12 удаагийн нэгдсэн үзлэг шалгалтыг явуулсан.

#### **ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

Хүний эрхийн үндэсний комиссын Хөвсгөл аймаг дахь салбарын төлөөлөгчтэй хамтран 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс 6 дугаар сарын сарын 9-ны өдөр хүртэл Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Галт, Шинэ-идэр, Жаргалант сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаа. Уг сургалтаар ХЭҮК-ын Хөвсгөл аймаг дахь референт М.Тунгалагмөрөн, ГБХЗХГ-ын Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Халиунаа, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч Н.Бүрэнчимэг, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Г.Бямбахишиг нар дээрх сумдын иргэдэд “Хүний эрхийн үндэсний комиссын танилцуулга”, “Хүний эрхэд суурилсан хүчирхийлэл”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгаалал” “Хууль зүйн туслалцааны тухайн хуулийн шинэчилсэн найруулга”, “Нууцтай байх эрх” “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн оролцоо, Хорт зуршилаас сэргийлье” зэрэг сэдвийн хүрээнд сургалт, мэдээлэл хийсэн. Сургалтад нийт 163 төрийн алба хаагч, иргэд 120 сурагч тус тус хамрагдлаа.

“Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдөр буюу “Хүүхдийн баяр”-ыг аймгийн хэмжээнд “нэгдүгээрт хүүхэд” уриан дор “Баярын талбай” буюу стадоинд нэгдсэн байдлаар тэмдэглэн өнгөрүүллээ. Арга хэмжээний хүрээнд хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Мөрөн сумын төв хэсгийн авто замын хөдөлгөөнийг 10.00-18.00 цагт түр

хязгаарлан 7 цэгт замын цагдаагийн 7 алба хаагч, хөдөлгөөнт эргүүлээр 2 алба хаагч үүрэг гүйцэтгэж замын хөдөлгөөний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж ажилласан. Тус газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагчид үлгэрийн баатар, хүүхэлдэйн хувцастай үүргээ гүйцэтгэж хүүхдүүдэд баярын мэндчилгээ хүргэж, тэднийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлж ажиллаа.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх хөтөлбөрийн дагуу цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн алба хаагч нар хариуцан хүүхдүүдийн дунд “Унадаг дугуй”-н уралдааныг зохион явуулж 1,2,3 дугаар байр эзлүүлэн үнэ бүхий эд зүйлээр шагнаан урамшуулсан. Хүүхдийн баярын арга хэмжээний үеэр хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус Цагдаагийн газрын алба хаагчид нэгдсэн эргүүлд ажиллаж, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллийг хүүхэд, эцэг эхчүүдэд хүргэж ажилласан

### **ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн хэмжээнд 2023 оны 06 дугаар сард гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг бүртгэгдээгүй, урд оны мөн үетэй харьцуулбал 100 хувь буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 119 зөрчил бүртгэгдсэнээс өмнө онтой харьцуулахад 39,6 хувиар буурсан үзүүлэлтэй. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

### **Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

“Нэг зам-нэг соёл” нэгдсэн арга хэмжээний зохион явуулах ажлын төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын даргаар 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдөр батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Нээлтийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 11:00 цагт улсын чанартай А0902 авто замд зохион байгуулсан. Орон нутгийн “Хөвсгөл Ард түмний телевиз”, “Хөвсгөл түмний телевиз”-д “Анзаар.мн”, “Хөвсгөлийн өнгө” цахим хуудсаар нээлтийн үйл ажиллагааг шууд нэвтрүүлсэн.

Мөн “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар”, “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг”, Хөвсгөлийн нэгдсэн зар”, “Орон нутгийн замын цагдаа” цахим хуудаснуудад оруулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан. Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт зам тээврийн осол, хэрэг давтамжтайгаар үйлдэгддэг хар цэгийг газрын зурагт авто замын сүлжээнд тэмдэглэн “Нэг зам-нэг соёл” бичиглэл бүхий А4, А5 хэмжээтэй 2500 ширхэг хэвлүүлэн Тариалан их сумын цагийн менежментийн пост, Мөрөн сумаас Хатгал чиглэлд явах хөдөлгөөнт, Хатгал тосгоны хяналтын пост, Мөрөн сумын хот хоорондын постуудаар дайран өнгөрч байгаа иргэдэд тараан хүргэсэн.

Мөн сумдын хэсгийн төлөөлөгч цагдаа нар цахимаар санамжийн эхийг хүргүүлэн хэвлүүлж орон нутгын жолооч нарт тараан хүргэж байна.

Суудлын автомашинуудад байрлуулах 2 төрлийн 2500 ширхэг санамж постерыг хэвлүүлэн тээврийн хэрэгслүүдэд нааж байрлуулан иргэдэд анхааруулга, зөвлөгөө өгч ажиллаа. “Мөрөн-Булган” чиглэлийн А0902, А1101 авто замуудад замын осол, хэрэг давтамжтайгаар үйлдэгддэг/хар/ цэгт аймгийн гэсмет хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 5х3 хэмжээтэй анхааруулах 4 ширхэг самбар байрлуулсан. Мөрөн сумын төв зам дагуу зам тээврийн осол хэргээс урьдчилсан сэргийлэх

чиглэлээр 60x120 хэмжээтэй 20 ширхэг анхааруулах самбар байршуулж ажилласан. Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний төвүүдийн лед дэлгэцээр “Нэг зам-нэг соёл” аяны хүрээнд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх 2 видео шторкыг иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Зам тээврийн осол хэргээс, урьдчилан сэргийлэх чиглэлээр Замын тасгийн алба хаагч магистрал зам дагуу хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч “Нэг зам нэг соёл” бичиглэл бүхий 100 ширхэг ослын гурвалжин тарааж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллаа. Mplus music аппликейшнд сонсогч нарт “Нэг зам нэг соёл” постерийг байршуулж 1.000.000 хүнд түгээсэн.

Замын цагдаагийн тасгаас аяны хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээ, урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, видео, шторк, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанаас бэлтгэн гаргасан шторк, санамж, сэрэмжлүүлэг мэдээллийн “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар”, “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг”, “Хөвсгөлийн өнгө”, “Anzaag.mn “Хөвсгөлийн нэгдсэн зар” нэртэй цахим хуудаснуудаар Цагдаагийн газраас 2 төрлийн санамжийг бэлтгэн хэвлүүлж цахим орчинд байрлуулж 20,000 иргэний хандалд авсан байна.

Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанаас оруулсан оруулсан постер, шторкуудыг тухай бүр нь дээрх цахим хуудаснуудад оруулсан. Арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа ажлын явц үр дүнгийн талаар Орон нутгийн “Хөвсгөл” телевизээр иргэдэд мэдээ, мэдээлэл 65 удаа, “Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг”, “Орон нутгийн замын цагдаа” “Бүх хөвсгөлчүүд энд”, “Хөвсгөлийн нэгдсэн зар мэдээ”, “Хөвсгөлийн зар”, Хөвсгөлийн нэгдсэн зарын групп” зэрэг цахим хуудаснуудаар 45000 иргэдэд мэдээлэл хүргэсэн.

### Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2023 оны 06-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **12.7** тэрбум төгрөгний **2643** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2023 оны 05-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 21,886.4 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 24,216.2 сая төгрөг буюу 110.6% хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2023 оны 05-р сарын мэдээгээр Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан 37,821.9 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 2,296.6 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 28,217.3 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 9,155.2 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс, 4,773.4 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 37,821.9 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 23,794.5 мянган төгрөг буюу 62.9 % хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,214.0** сая төгрөг өмнөх сараас **13.1** сая төгрөгөөр буурсан.

Нийт өглөг **1,201.6** сая төгрөг өмнөх сараас **132.8** сая төгрөгөөр буурсан.

2023 оны 06 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 4021.6 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 307.6 сая төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 98.9%-тай байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	3177	3483.1	109.6
Тэтгэмж	321.5	380.3	118.3
ҮОМШӨ	240.6	304.1	126.4
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	60.0	73.0	121.7
дүн	3799.1	4240.5	119.0

Тэтгэврийн даатгалын сангаас 21761 тэтгэвэр авагчид 11046.5 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 3 төрлийн тэтгэмж 355 даатгуулагчдад 348.3 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, үйлдвэрлэлийн ослын сангаас 67 даатгуулагчдад 33.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 93 даатгуулагчид 69.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 116.9 сая төгрөг байна.

Санхүү хяналт дотоод аудитын алба 2023 оны 06 дугаар сард аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянзүрх суманд, байгууллагын төлөвлөгөөний дагуу Цэцэрлэг суманд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний зардлын үр дүн, гүйцэтгэлд, Түрээсийн орон сууцны эргэлтийн сан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний үр дүн, гүйцэтгэлд хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

2023 оны 06 дугаар сарын байдлаар 266 албан бичиг хүлээн авч, хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 96 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Оны эхнээс 23 өргөдөл, хүсэлт хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн 21, хянагдаж байгаа 1, хугацаа хэтэрсэн хяналт шалгалтын явцад буй 1 өргөдөл байна.

**Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

МУБИС-н ДУТС-н тэнхэмийн багш доктрант Ч.Батцэцэг “ЗООСОН ШИРЭЭН СҮЛЖМЭЛ” сургалтыг Хөвсгөл аймгийн дизайн технологийн эмэгтэй багш нарт орсон бөгөөд тус сургалтад хамрагдсан 7 багш нь Хөвсгөл аймагт сургагч багшаар ажиллах эрхтэй боллоо.

Боловсролын үнэлгээний төвийн захирал Л.Ганбатын 2023 оны 04 сарын 03-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан “2023 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын журам”-ын 3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2023 оны 06 дугаар сарын 15-аас 06 дугаар сарын 18-ны өдөр БҮТ-ийн мэргэжилтэн Н.Очирсүх ахлагчтай баг, Хөвсгөл аймгийн БШУГ-ын мэргэжилтнүүд, Хөвсгөл аймаг дахь Тагнуулын газар, Цагдаагийн газрын албан хаагчдын хяналтад, “Дэлгэрмөрөн цогцолбор”, “Ирээдүй XXI зуун ахлах цогцолбор” сургуулийн удирдлагуудын дэмжлэгтэйгээр, Мөрөн сумын багш нартай (Хянагч) хамтран амжилттай зохион байгуулав.

Монгол бичгээр уншиж, бичих үндсэн чадварыг хөгжүүлэх, “Багшийн үйл ажиллагаагаар - Шавь нарыг, Шавь нарынх нь чадвараар - Багшийг нь алдаршуулж сурталчлах” зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Үндэсний өв соёлоо түгээгч, тээгч” улсын уралдаанд Хөвсгөл аймгаас 6 дугаар ангийн 9, 7 дугаар ангийн 10, 8 дугаар ангийн 6, 9 дүгээр ангийн 7, 10-12 дугаар ангийн 22 бүлэг, нийт 54 бүлгийн 1400 гаруй сурагч амжилттай оролцов.

Академич, төр, нийгэм, боловсрол, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, Базарын Ширэндэвийн эснэсний 110 жилийн ойн хүрээнд Хөвсгөл аймаг Мөрөн суманд 2022-11-11 өдөр зохион байгуулсан “ХӨВСГӨЛ СУДЛАЛ-2022” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл хэвлэгдэн гарлаа.

Салбар дундын инновац шингэсэн бүтээл, судалгааны ажлуудыг судлан аймгийн хөгжлийн бодлого, стратегийн шийдлийг эрэлхийлсэн, шинэ санаа, санаачилгыг дэвшүүлсэн судалгаа, илтгэл, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг олон нийтэд хүргэх, түүний үр дүнг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, орон нутгаас төрөн гарсан эрдэмтэн, судлаачтай хамтран ажиллах, тухайн бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэх асуудлыг шинжлэх ухаанчаар харах, үнэлэлт дүгнэлт зорилгын дор томоохон ажил болсон юм.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор салбар дундын оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 6 сарын 1-ний өдөр нэгдсэн арга хэмжээг амжилттай зохион байгуулж, Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүд, Аймгийн хүүхдийн зөвлөлийн сурагчидтай хамтран, “Шинжлэх ухаанч хүүхдүүд” танин мэдэхүйн өртөөгөөр 200 гаруй хүүхдийг аялууллаа.

“Шинжлэх ухаанч хүүхдүүд” танин мэдэхүйн өртөөнд байгалийн ухааны судлагдахууны агуулгад суурилсан

1. Галт уул

2. Lava lumb

3. Хөөсөн гал

4. Гал унтраагч зэрэг туршилтууд явагдаж, хүүхдүүдийн танин мэдэхүй, мэдлэг чадварыг сорил туршилтаар үзүүлж, сонирхсон хүүхдүүд аюулгүй ажиллагаа зааварчилгааг мөрдөн хамтран туршилт хийж нэгэн өдрийг бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэн сонирхолтой, дурсамжтай өнгөрүүлээ.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Мөн Улсын хэмжээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах “Бэлэн бай” аян зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан тус аянд Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нэгдэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, бэлэн байх зорилгоор үзүүлэх сургалтууд болон зөвлөмж мэдээллүүдийг олон нийтэд танилцуулж ажилласан..

“Хөвсгөл аймагт зочлох жил”, “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд спортын бага наадам Хөвсгөл аймгийн төв Мөрөн суманд зохион байгуулагдлаа. Тус наадам нь Эрүүл мэндийн газруудын албан хаагч нар танилцах, хамтын уялдаа холбоог сайжруулах, бүх нийтэд



спорт, нийтийн биеийн тамирыг сурталчлан таниулах зорилгын хүрээнд явагдаж байна. Шилжин явах цомтойгоор уг наадам жил бүр уламжлал болон 5 дахь удаагаа зохион байгуулагдаж байгаа ба гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис, дартсын 4 төрлөөр өрсөлдөж аваргуудаа тодрууллаа.

Хөвсгөл аймагт "Настны цогц тусламж үйлчилгээ, эрүүл насжилтад бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн яам, Геронтологийн үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн газар хамтран зохион байгуулж, АЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, Мөрөн сумын ахмадын хороо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Өрхийн эрүүл мэндийн төв, Ахмадын асрамжийн газар, Ахмад сувилагчдын нийгэмлэг, ахмад сувилагчдын "Итгэл сэтгэл" бүлгэмийн төлөөллүүд оролцож мэдээлэл хийж, ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, цаашид хамтран ажиллах чиглэлээр харилцан ярилцлаа.

Мөн Геронтологийн үндэсний төвийн эмч мэргэжилтнүүд Мөрөн сум, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумын ахмад настнуудаас судалгаа авч, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад үений ЭХО, ясны сийрэгжилтийн үзлэг, оношлогоог хийлээ.

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Нийгмийн халамжийн ehalamj.mn системээр 2023 оны 6 сард 75772 иргэнд 7.5 тэрбум төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс 2 удаа хуралдаж 38 хүүхдийн асуудлыг хэлэлцэн, 13 хүүхдэд байнгын асаргаа тогтоон үйлчилгээнд хамруулж, хугацаатай байнгын асаргаанд байдаг 19 хүүхдийн асаргааг сунгаж, 1 хүүхдийн өргөдлийг буцаан, 1 хүүхдийн онош тодруулах шийдвэр гарган ажилласан байна.

ЗГХЭГ-аас Сэлэнгэ аймагт зохион байгуулсан төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл хийхтэй холбоотой сургалтад аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 5 албан хаагч хамрагдаж чадавхажсан.

ОНОТХҮ-ээр 220 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний EJOB платформд 692 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 77 иргэнийг ажлын байранд зуучилсан байна. Ажил хайгч болон зорилтот бүлгийн 516 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад 3 хоногийн хугацаанд цахим танхим хосолсон хэлбэрээр хамруулж, чадамжийн гэрчилгээ олголоо. Сургалтад оролцогчдыг Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8 аж ахуй нэгж, ажил олгогчийн нээлттэй ажлын байртай танилцуулах уулзалт арга хэмжээг зохион байгуулж, 4 иргэнийг ажлын байранд зуучилсан. Идэвхтэй ажил хайгчаар 236 бүртгэгдээд байна.

Аймгийн Засаг даргын "Ажлын байр, ажиллах хүчний мэдээллийг сайжруулах тухай" 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 04 албан даалгаврын хэрэгжилтийг ирүүлэх тухай албан бичигт дүн шинжилгээ хийж байна.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 8 сумын 79 иргэнийг хамруулж 28,4 сая төгрөг, Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажилд 7 сумын 79 иргэнд 28,4 сая төгрөгийн цалин хөлсийг олгон ажилласан байна.

Малчдыг малжуулах арга хэмжээний хүрээнд 37 малчин өрхөд 185 сая төгрөгийн мал хүлээлгэн өгч санхүүжилт олгож ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй санхүүгийн дэмжлэгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 85, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 114, ахмадын зөвлөх үйлчилгээ 44, иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 236 төсөл ирүүлснийг хүлээн авч танилцан, ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, эхний шатны шалгаруулалтыг хийлээ.

Хөдөлмөрийн хамтын гэрээ шинээр 2-ыг бүртгэж, 7 дугаар сарын байдлаар нийт 9 гэрээг бүртгэв. Үүнээс нэмэлт өөрчлөлт оруулсан 2 гэрээ байна.

2023 оны 07 дугаар сард зохион байгуулах ажил олгогч, нийт ажилтныг чадавхжуулах, сертификаттай сургалтын удирдамж, 8 дугаар сарын 15-аас 11 сарын 15-ны хооронд зохион байгуулах “Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах аймгийн үзлэг”-ийг зохион байгуулах удирдамжийг тус тус боловсруулах, ажлын хэсэг байгуулах, хөрөнгө зарцуулах тухай аймгийн засаг даргын захирамж гаргуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль тогтоомжийн эмхэтгэл хэвлүүлэхээр эхийг бэлтгэх ажлыг 06, 07 дугаар сард гүйцэтгэж байна. Энэхүү гарын авлага нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох тогтоол шийдвэр, журам, стандартыг хамруулснаараа гол онцлогтой.

Орон нутгийн төсвийн тодотгол хэлэлцүүлэхэд Аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо болон Хөдөлмөрийн аюулгүй байдлын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд тус бүр 10,0 сая төгрөг төсөвлүүлэхээр саналыг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 79 дүгээр тогтоолыг үндэслэн Барилга хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хяналт шалгалтын объектын жагсаалтыг үндэслэн барилга угсралтын чиглэлээр болон салбарын хяналтын газрын баталсан Уул уурхай болон газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт, түгээлт, ашиглалтын үйлдвэрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нар Могойн голын уурхай, Хатгал тосгонд Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг, Ханх сумдад барилга угсралтын чиглэлээр 13 объект, хөрөө рам 13 объект, төлөвлөгөөт бус 6 объект хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Улсын байцаагчийн зөвлөмжийг хяналт шалгалт хийсэн байгууллагуудад хүргүүлсэн.

## **БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Соёл урлагийн газрын санаачилгаар зохиолч Ц.Гончигийн “Зүүд урлаач хугаашан” хүүхдийн жүжгийг Хөгжимт драмын театрын мэргэжлийн уран бүтээлчид үзэгч хүүхэд багачууддаа бэлэг барин 50\*100 event hall-ын танхимд 4 удаа амжилттай тоглолоо.

Хөгжимт драмын театрын уран бүтээлчид 6 дугаар сард Алаг-Эрдэнэ суманд “Хөвсгөл түмний аялгуу” теле концертийн зураг авалтыг хийж гүйцэтгэлээ.

ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний Музей, Монгол-Америкийн хамтарсан “Умардын хязгаар” төслийн судлаачдын санаачлан зохион байгуулж буй “Өв

хамгаалагчид” зуны сургалтад хамрагдаж буй Шишгэд бүсийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ сумдын багш, сурагчдыг музейн тайлбарт аялалд хамрууллаа.

“Зуны зугаатай уншлага” уриан дор “Соёмбо цогцолбор” дээр зөөврийн номын сангийн үйлчилгээг өдөр бүр явуулж байна.

“Соёмбо цогцолбор” дээр зөөврийн номын сан ажиллаж аялж, амарч яваа иргэдэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдэж, ном унших дадал хэвшилд хүүхэд багачууд суралцан зуныг зугаатай уншлагатай хамтдаа өнгөрүүлж байна.

Олон Улсын Олимпын өдрийг угтан спортын номын үзэсгэлэнг гэрээр ном олгох танхимд байршуулж, үндэсний хувцас, хэрэглэлтэй холбоотой ном товхимлоор үзэсгэлэн бэлтгэн тавив.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 58 дугаар тэмдэглэлээр албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүр шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгосон. Үүний хүрээнд И-Монгол академи, Архивын ерөнхий газар хамтран албан бичиг солилцооны дундын "DOCX" системийг ашиглах талаар арга зүйн зөвлөмж өгөх сургалтад хамрагдлаа.

Монголын хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, Монголын хараагүйчүүдийн Үндэсний Холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл хамтран агентлаг, байгууллагын удирдлага болон холбогдох мэргэжилтнүүд холбооны гишүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүд, МХҮХ-ноос явуулж буй үйл ажиллагаа мөн хараагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, харааны бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол, хөдөлмөр эрхлэх боломжийн талаар мэдээлэл хийж цаашид хараагүй иргэдэд тулгамдаж буй асуудлыг тэдний өөрсдийнх нь оролцоотой хэрхэн хамтран шийдвэрлэх талаар хэлэлцэх сургалтад хамрууллаа.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 арга зүйн цахим сургалтыг “Монгол мандсан шалтгаан” сэдвийн доор Нэрт түүхч, түүхийн ухааны доктор, Төрийн шагналт “Монголчууд цахим түүх” сонсдог номын зохиогч Дэмбэрэлийн Өлзийбаатар зохион байгуулав.

“Эерэг хандлага –Эрүүл нийгэм” цаг гаргая аяны хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооноос 8 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөн туслах ажиллагаа зохион байгуулагдаж, Фитнессийн магадлан итгэмжлэл сорил судалгааны талаар зааварчилгаа өгч Биеийн тамирын багш, дасгалжуулагч нарын 13 хүн хамрагдлаа. Өсвөрийн тамирчны 12 чанар, үе бэхжүүлж мэдрэмж дээшлүүлж ирээдүйд олимп, дэлхийн аварга бэлтгэх тал дээр хэрхэн анхаарах, ЕБС-ийн сурагчдын сургалтын шинэ арга барил, гимнастикийг нэгэн зэрэг хүүхдүүдэд хэрхэн хөгжмийн аяар удирдаж болох сургалтын чухал ач холбогдлыг тайлбарлалаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдөр “Нэгдүгээрт хүүхэд” хүүхдийн баяраар ЗХЗ Сагсан бөмбөгийн тэмцээнийг ахлах ангийн хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгууллаа.Тус тэмцээнд 15-17 нас эрэгтэй, эмэгтэй тус бүр 8 баг нийт 16-н багийн 64 тамирчид хурд хүч авхаалж, самбааг сорин өрсөлдөж дүнгээ гаргалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Цаг гаргая” аяны хүрээнд зохион байгуулсан “Нийтийн цэнгээнт бүжиг” -ийн тэмцээнийг Медиалтай тамирчин буюу “А” ангилал, Медиалгүй тамирчид буюу “В” ангилал 2 ангиллаар зохион байгуулж нийт 11 байгууллага, клубын 200 гаруй иргэд бүжигчид оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар улс орон даяр явагдаж байгаа "ЦАГ ГАРГАЯ" аяны хүрээнд Хөвсгөл аймгийн биеийн тамир спортын газар, Хөвсгөл аймгийн

бүжгийн холбоо, Аялгуу бүжгийн холбоотой хамтран "БҮЖИГЛЭХЭД ЦАГ" гаргая 7 хоногийн аяныг зарлаж давхардсан тоогоор нийт 700 гаруй иргэн оролцсон байна.

Хангайн бүсийн аварга шалгаруулах Хөлбөмбөгийн тэмцээнд Орхон, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд өрсөлдөж тэмцээнийг аймгийн хөл бөмбөгийн холбоо, Монголын хөл бөмбөгийн холбоо, аймгийн Биеийн тамир, спортын газар хамтран 3 өдрийн турш амжилттай зохион байгууллаа

МУГТ Доржпаламын Нармандахын нэрэмжит өсвөр үеийн жүдо бөхийн аварга шалгаруулах олон хотын нээлттэй тэмцээнд нийт 43 байгууллагын 1700 гаруй тамирчид оролцож Хөвсгөл аймгийн БТСГ-ын баг тамирчид амжилттай оролцон эмэгтэй багийн дүнгээр 3р байранд шалгарлаа. Охидын 40 кг жинд О.Тэлмүүн, 44 кг жинд Т.Отгонжаргал алтан медаль хүртэж мөн 3 мөнгө, 4 хүрэл медаль авсан амжилт гаргалаа.

Орхон аймгийн Эрдэнэт хотод АНУ-алдарт бөх Олимпын аварга Жон Петерсоны нэрэмжит бөхийн чөлөөт барилдааны өсвөр үе, залуучуудын Олон улсын тэмцээн болж Хөвсгөл аймгийн 17-н тамирчин, 2 дасгалжуулагчийн удирдлага дор амжилттай оролцож 4 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль авлаа.

Хөвсгөл аймгийн өсвөрийн жүдочид УАШТ-нд 96 тамирчинтай оролцож 3 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж мөн холимог багийн 9 дэх удаагийн УАШ тэмцээнд баг насны төрөлд анх удаагаа түрүүлсэн амжилтыг үзүүллээ.Тус тэмцээнд жүдо бөхийн хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс эрхээ авч оролцсон тамирчдын дасгалжуулагчид Монгол Улсын холимог багийн аварга баг боллоо.

2023 оны 06 сарын 14-16 өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Монгол Улсын гавьяат дасгалжуулагч С. Ган-Эрдэнийн нэрэмжит Улсын аварга шалгаруулах Таеквондогийн , тэмцээнд Хөвсгөл аймгаас 14 хүүхэд оролцож 3 алт , 1 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.

Монголын хүүхдийн спортын 7-р их наадам Баянхонгор аймагт 2023 оны 06 дугаар сарын 19-29 ны хооронд 11 өдрийн турш 21 аймаг 9 дүүргээс шалгарсан 4900 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорьсноос Хөвсгөл аймгаас нийт 173 хүний бүрэлдэхүүнтэй Тамирчин 159, албаны хүн 1, дасгалжуулагч 6, Жолооч 7 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 6 алт, 9 мөнгө, 8 хүрэл медаль хүртэж 6-р байрт шалгарсан амжилт гаргалаа.

### **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2023 оны 06 дугаар сард 9 үйл ажиллагаа, үйлчилгээ, сургалт, нөлөөллийн ажилд 16834 хүүхэд /давхардсан тоогоор/, 334 насанд хүрэгч, 101 гэр бүл, 295 залуучууд хамрагдсан байна.

Байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан 8 зөвлөмж, 14 мэдээ, 1 сэрэмжлүүлэг, 1 ажлын байрны зар, 4 танилцуулгыг иргэд олон нийтэд хүргэж 437 хандалт авсан байна.

ГБХЗХГ-ын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр нийт 38 иргэн үйлчлүүлсэн байна. Үүнээс өдрөөр насанд хүрэгч 23 /17 эмэгтэй, 6 эрэгтэй/, 15 хүүхэд /6 эрэгтэй, 9 эмэгтэй/, 12 иргэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлсэн.

Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд эцэг эхчүүдийн оролцоо, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг төлөвшүүлэх, хүний хувийн нууц, хүний эрх хамгаалагчийн талаарх мэдээллийг түгээх зорилгоор ХЭҮК-ын Хөвсгөл аймаг дах референт, аймгийн ЦГ-тай хамтран Төмөрбулаг, Шинэ-Идэр, Галт, Жаргалант суманд ажиллаж нийт 300 хүнийг хамрууллаа.

Гэр бүлийн чиглэлээр мэргэшсэн лектороор дамжуулан Мөрөн сумын 100 залуу гэр бүлийн 200 хүнд “Миний гэр бүл - миний үнэ цэн” арга хэмжээг зохион байгуулж, гэр бүлийн эерэг, хамтач харилцааг эрхэмлэх, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлж, гэр бүлийн боловсрол олгов. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, шүүхийн шийдвэрээр баривчлагдсан 11 иргэнд хүчирхийллийн зан үйлийг өөрчлөх, гэр бүлийн харилцааны сэтгэл зүйн боловсрол олголоо.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/269 дүгээр захирамжаар Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж “Нэгдүгээрт хүүхэд” уриа дор Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, 14 төрлийн арга хэмжээнд, 8468 хүүхдийг хамруулж, 19 орчим байгууллагуудын оролцоотойгоор тэмдэглэн өнгөрүүллээ. Хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Мөрөн сумын 14 цэгт хяналт шалгалт хийгдэж, зөвлөмж өгч ажиллалаа.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн болон хувийн амьдралдаа адил тэнцүү үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, тэгш хариуцлага, тэгш оролцоотой болох чиглэлээр газрын мэргэжилтнүүд чадавхжиж, энэ сард 185 залуучуудад мэдээлэл өгч ажиллалаа.

Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж тогтоолгон, хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай иргэний хэрэгт хүүхдээ хэн нь асран хамгаалах боломжтой эсэхэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах тухай захирамжийн дагуу Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/63 дугаар тушаалаар шинжээчийн баг Бүрэнтогтох суманд ажиллалаа.

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, шүүхийн шийдвэрээр баривчлагдсан иргэдийн хүчирхийллийн зан үйлийг өөрчлөх, гэр бүлийн харилцааны сэтгэл зүйн боловсрол олгож, гэр бүлийн хүчирхийлэлгүй эерэг харилцааг бий болоход нөлөөлөх зорилгоор зан үйлд нөлөөлөх “Тайван амьдрал Танай гэрээс-2” сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж байна.

Арбулаг сумын Цагаанчулуутын овооны тахилга, наадамд ажиллаж, хурдан морь уралдаанч хүүхдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хууль, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Оюун сэтгэхүй хөгжүүлэх, хурдны гайхамшиг спорт өрөлтийг бүх насныханд сурталчлан таниулах, тус спортоор хичээллэж буй хүүхэд, өсвөр үеийнхний ур чадварыг нэмэгдүүлэх, дотоод болон гадаадын тэмцээн, уралдаанд оролцох шилдэг тамирчдыг тодруулж, ирээдүйн мэргэжлийн тамирчдыг бэлтгэх зорилготойгоор аймгийн аварга шалгаруулах “Оюуны гайхамшиг-II” тэмцээн зохион байгуулагдав.

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам болон Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас хүүхдийн эрхийг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Олон улсын байгууллагын санаачилгыг дэмжин “Найз байя” нөлөөллийн аяныг Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгонд зохион байгууллаа.

“Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал” сургалтыг аймагтаа зохион байгуулж, 295 залуучуудад хүрч ажилласан.

### **Тав. Мал аж ахуй, газар тариалангийн талаар:**

#### **Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:**

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, МЭЕГ-ын даргын 2019 оны А/04 тушаал “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг хэрэгжүүлэн, аймаг сумын засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн засаг даргын 2023 оны 05 сарын 31 өдрийн А/16 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 05 өдрийн А/28 тушаал, Бог малын

мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад хонь-238,411, ямаа-2,191,953 хурга-768,234, ишиг-434,294, нийт-3,632.892 толгой бог малыг хамруулахаар хамруулахаар төлөвлөн дархлаажуулалтын ажил 2023 оны 06 сарын 8-ний өдрөөс эхэлж 2023 оны 07 сарын 23-ний өнөөдрийн байдлаар 3,496,555 мал хамрагдаж 96.2 хувийн гүйцэтгэлтэй дархлаажуулалтын ажил хийгдэж дуусан байна. Бог малын мялзан өвчний дархлаажуулалтын дараах хяналтыг 23 суманд хийж гүйцэтгэсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 сарын 10-ний өдрийн А/34 тоот тушаал, 2023 оны 03 сарын 03-ний өдрийн А/48 тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 01 албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2022 оны 03 сарын 10-ний өдрийн А/96 “Ариутгал, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажил зохион байгуулах тухай” захирамжийн дагуу аймгийн хэмжээнд нийт 130116 мянган том малын зүй бус хорогдол гарсны 126769 ш сэг зэм буюу 97.4 хувь цуглуулж устган 1.585,155 м2 талбайд халдваргүйтгэл хийгдэж дууссан байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд угаалга-3696314, туулгалт-1861149, боловсруулалт-1929538, үхрийн арьсны гуурын боловсруулалт- 504955, нийт-7,991,956 малыг хамруулахаар төлөвлөн өнөөдрийн байдлаар гүйцэтгэл: угаалга -517413 мал хамрагдаж 14 хувь, 390841 мал хамрагдаж, туулгалт-20,5, хувийн гүйцэтгэлтэй, 347316 мал хамрагдаж, боловсруулалт-18, хувийн гүйцэтгэлтэй байна.

Өнөөдрийн байдлаар бог малын мялзан өвчин оношлогдсон Бүрэнтогтох, Рашаант, Төмөрбулаг, Тариалан сумд сумын засаг даргын захирамжаар, хязгаарлалтын дэглэмээ цуцалсан. Нэмж малын өвчлөл, хорогдол бүртгэгдээгүй байна. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын сарын аяны тараах материал том-140 ширхэг, дунд-130 ширхэг, жижиг-1200 ширхэг тараах материалыг сум тус бүрт хувиарлан хүлээлгэн өгч ажиллаа.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний хөлсний материалыг нэгтгэн баталгаажуулж, аж ахуйн нэгж тус бүрээр, нэг бүрчлэн, тулгалт хийж авч дууссан. Бог малын мялзан өвчний үйлчилгээний хөлсний материалыг 74 аж ахуйн нэгж баталгаажуулан ирүүлж цахим системтэй тулгалт хийж ажиллаа.

### **Сорил, шинжилгээ, оношлогооны талаар**

Нян судлал, молекул биологийн тасагт 2 сумын 2 эсктезээр 2 дээж хүлээн авч шинжилгээг хийж Тариалан суманд Цусан халдвар, Их-уул суманд брадзот тус тус 2 өвчин оношлогдсон. Хүнсний ариун цэврийн тасагт 2 сумын 3 дээж хариуг холбогдох газарт хүргүүлсэн байна. Ийлдэс судлалын тасагт 3 сумын 800 хээлтүүлэгчийн цусны дээж хүлээн авч шинжилгээг хийсэн.

### **БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хүрээнд БНАТ-1, БНАТ-2 маягтыг сумдаар шивүүлж заавар зөвөлгөө өгч ажиллаж байна.

Аймгийн агнуурын бодлогын хэрэгжилт, агнуурын бүс нутгийн төлөв байдалд үнэлгээ мониторинг хийх ажлын хэсэг манай аймагт ажиллаж байгаатай холбогдуулан аймгийн ан

агнуурын менежментийн төлөвлөгөө, агнуур зохион байгуулалт, загас агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хууль бусаар тарвага агнах, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сумдад хяналт шалгалтыг тогтмол хийж мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ойн санд тархсан хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 9 сумын нутаг дэвсгэрт нийт 31000 га талбайд үүргийн шүршигч болон агаарын хөлөг ашиглан “Залуу төгөл” ХХК, “Томас Эйр” ХХК хамтран гүйцэтгэв. Тэмцлийн ажлыг “Шим” ХХК-д үйлдвэрлэсэн “BM-MN013” бактерийн бэлдмэл ашиглан гүйцэтгэсэн.

Мөрөн сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг тогтмол хийж байна.

Аймгийн хэмжээнд 2023 он, 2024 онд тарьсан модны амьдартын хувийг тооцох, тарьц суулгацны нөөцийг нарийвчлан гаргах ажлыг зохион байгуулав.

“Нэмэн” ХХК-ны Мөрөн сум 2 дугаар баг, Хатгал гарах замд байрших шатахуун түгээх станцад Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг гаргаж өгсөн.

Тариалан сумын 3 дугаар баг, Таван толгой, Урхитын хөндийд хийгдэх “Хог хаягдлын нэгдсэн цэг байгуулах” ажлын Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг гаргаж өгсөн. Хийгдсэн 2 үнэлгээг байгаль орчны мэдээллийн сан [www.eic.mn](http://www.eic.mn)-д шивж оруулсан.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/356 захирамжаар аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, аймгийн нэгдсэн санд орлого төвлөрүүлэх ажлын хэсэг байгуулагдан 12 хүний бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 14 дүгээр тогтоолоор 2023 оныг “Хөвсгөлд зочлох жил”-ээр зарласантай уялдуулан гадаад дотоодын жуулчдыг татах зорилгоор олон арга хэмжээг зохион байгуулж тэдгээрийг зорин ирэх жуулчдын тоо нэмэгдэж байна. 2023 оны эхний 7 сарын байдлаар нийт 72316 жуулчин Хөвсгөл аймагт ирсэн бөгөөд үүнээс ХНБЦГ-ын нэвтрэх цэгээр 2023 оны 6 сарын 10-аас 7 дугаар сарын 25 -ны хооронд 56666 жуулчин орсон. Одоогоор гадаад жуулчдын тоо гараагүй байна.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА